

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудитын тайлан	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	6
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн.....	8
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	14
2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	15
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	17
2.12. Шилэн дансны мэдээлэл	18
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	18
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	18
3. Менежментийн захидал.....	19
3.1. Балансын данстай холбоотой асуудал.....	19
3.2. Балансын данстай холбоотой асуудал.....	19
3.3. Балансын данстай холбоотой асуудал.....	20
3.4. Зардлын данстай холбоотой асуудал	20
3.5. Зардлын данстай холбоотой асуудал	20
3.6. Орлогын данстай холбоотой асуудлууд	20
3.7. Тухайн байгууллага, салбарын хууль эрх зүйн орчин холбоотой асуудал.	21
3.8. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаатай холбоотой асуудал.....	21
3.9. харьяа байгууллагуудад илэрсэн зөрчилтэй холбоотой асуудал	22
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	23
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	23
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	24
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	24
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	25
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	26
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	28

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ГСА	Геологи санхүүжилтийн ажил
ҮЦК	Үнэт цаасны компани



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН
САЙД Д.СУМЪЯАБАЗАР ТАНАА

2020.04.24 № 1445
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Уул уурхай, хүнд үйлдвэрийн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС, СТОУС -д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу үнэн, бодит, шударга, илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэлтэй санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал


Уул уурхай, хүнд үйлдвэрийн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн 4,392,689.1 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчлүүд бидний тооцсон материаллаг байдлын түвшний 43,647.2 сая төгрөгөөс давсан нь “Хязгаарлалттай санал дүгнэлт” өгөх үндэслэл болсон. Тухайлбал:

- Геологийн судалгааны ажлын хийж гүйцэтгэсэн зарим гэрээт ажлын биелэлт, судалгааны ажлын тайланг тухай бүр хүлээн авч дүгнээгүйгээс нийт 16,795.0 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийн тооцоог хийгээгүй он дамжуулан үлдэгдлээр бүртгэсэн байна;
- Ашигт малтмал, газрын тосны газрын төсөвт төвлөрүүлэх орлого 105,580.2 сая төгрөгөөр тасарсан;
- Харьяа ТӨҮГ-ууд нь 249,253.7 сая төгрөгийн авлага, 438,311.3 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй;
- зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.



Д.ЗАНДАНБАТ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах, төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлэх, авлага, өр төлбөрийг барагдуулах, геологийн судалгааны ажлын урьдчилгааг үнэн зөв хуримтлуулан бүртгэх, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-т заасны дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, СТОУС түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 04 дүгээр сарын 05-аас 2020 оны 04 дүгээр сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын аудитор П.Амарсанаа, гэрээт аудитор Ш.Ичинхорлоо нар гүйцэтгэв.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 01/922 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдийн сонгон шалгаруулалтад маргаан гарсны улмаас Үндэсний аудитын газар 2020 оны 4 дүгээр сарын 04-өөс 5 дугаар сарын 04-ний хооронд аудит хийсэн. Мөн аудитаар тус ТӨҮГ-ын санхүүгийн тайланд нийт 294,088.9 сая төгрөгийн залруулга хийгдсэн зэрэг

шалтгаалан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитыг Төсвийн тухай хуулийн 8.9.5-д заасан цагалбар хугацаанд хийгдээгүй болно.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, СТОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны эрхэм зорилго нь ил тод, хариуцлагатай уул уурхай, хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулж, эдийн засгийн тэнцвэртэй олон тулгуурт бүтцийг бий болгоход оршино.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Геологийн салбарын бодлого, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, геологийн судалгаа, ашигт малтмалын хайгуулын ажлыг эрчимжүүлж, эрдэс баялгийн сан хөмрөгийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;
- Уул уурхайн салбарын бодлого, эрх зүйн орчныг боловсронгуй болгож бүх төрлийн ашигт малтмалын олборлолт, баяжуулалт, борлуулалт, экспортын асуудлыг бодлогын удирдамжаар хангах замаар улс орны эдийн засгийн чадавхыг дээшлүүлэх;
- Хүнд үйлдвэрийн салбарын бодлого, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, тэргүүний технологи, инновацыг нэвтрүүлэх, нутагшуулах, шинэчлэх, замаар үйлдвэрлэл, технологийн паркийг байгуулах, хөгжүүлэх;
- Түлш, газрын тосны салбарын бодлого, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож газрын тос, уламжлалт бус газрын тосны (нүүрсний давхаргын метан хий, шатдаг занар, тослог элс гэх мэт) эрэл, хайгуул, ашиглалтын ажлыг эрчимжүүлэх, олборлолт, борлуулалтыг тогтвортой урт хугацаанд хадгалж, боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх, газрын тосны бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, түлшний чанар, стандартыг сайжруулж, агаарын бохирдлыг бууруулах;
- Геологи, уул уурхай, түлш, хүнд үйлдвэрийн салбарын эдийн засгийн үр ашиг, санхүүгийн чадавхыг сайжруулах, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг татах;
- Салбарын удирдлага болон тогтолцоог боловсронгуй болгох, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх замаар өрсөлдөх чадавхыг дээшлүүлэх;
- Геологи, уул уурхай, газрын тос, түлш, хүнд үйлдвэрийн салбарт техникийн шинэчлэлт хийж, байгаль орчинд хал багатай, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх;
- Иргэний нийгмийн оролцоонд суурилсан ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга” болон “Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх санаачилга”, тэдгээрийн зарчмууд болон стандартыг нэвтрүүлэх;

- Геологи, уул уурхай, газрын тос, түлш, хүнд үйлдвэрийн салбарын ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудалд анхаарч ажиллах;

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглах салбарын бодлогын баримт бичиггүй байгаа нь харьяа ТӨҮГ-ууд, болон бусад байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлан алдаатай илэрхийлэгдэх, холбогдох стандарт, хууль дүрэм, журам хэрэгжихгүй байх эрсдэлтэй байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд их гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар тайлант онд харьяа газруудад аудит хийх үйл ажиллагааны төлөвлөгөөнд хэрэгжүүлэх 44 арга хэмжээг баталж, төлөвлөгөөний биелэлтийг 97.5 хувиар дүгнэсэн байна. Харьяа газруудын санхүүгийн үйл ажиллагаанд 2, гүйцэтгэлийн 1, нийцлийн 2, сэдэвчилсэн 6 аудит хийж, илэрсэн зөрчилд 41 зөвлөмж хүргүүлэн ажилласан байна.

Мөн Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор УУХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний төсвийн 11 байгууллагад 7 хоног, сар, улирал бүр хяналт тавьж, хугацаа хоцорсон болон мэдээлэл байршуулаагүй 57 зөрчилд зөвлөмж хүргүүлэн 1 ажилтанд сахилгын арга хэмжээ тооцуулан, зөрчлийг тухай бүр нь арилган, мэдээ тайлан нэгтгэн холбогдох газруудад хүргүүлэн ажилласан байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 9 эрсдэлтэй асуудалд 9 горим хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба гүйцэтгэлийн үе шатанд 5 горим нэмж тодорхойлон эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 14 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь

үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшинг аудитлагдсан санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,182,361.8 сая төгрөгийн 2 хувь буюу 43,647.2 төгрөгөөр шинэчлэн тогтоов.

2.8. Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн

2.8.1. Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 625,989.5 сая байсан бол эцсийн үлдэгдэл 1,064,359.7 сая төгрөг болж, 438,370.2 сая төгрөгөөр өссөн байна

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	50.5	139.1	88.6
Банканд байгаа бэлэн мөнгө	624,989.0	796,301.8	171,312.8
Замд яваа мөнгөн хөрөнгө		340.0	340.0
Хадгаламж	950.0	267,578.8	266,628.8
Дүн	625,989.5	1,064,359.7	438,370.2
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	2,027.5	2,766.6	739.1
ТӨҮГ	623,962.0	1,061,593.1	437,631.1
Дүн	625,989.5	1,064,359.7	438,370.2

Эх сурвалж: Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Банканд байршиж буй 796,301.8 сая төгрөгөөс гадаад валютаарх үлдэгдэл 570,237.5 сая төгрөг байна. Үүнээс 2,766.6 сая төгрөг төсөвт байгууллагын, 793.535.2 сая төгрөг ТӨҮГ-уудын үлдэгдэл байна.

Замд яваа мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 340.0 сая төгрөг нь Багануур ХК-ийн Цахилгаан станцад нүүрс борлуулсны төлбөр байна.

Хадгаламжийн дансанд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 115,081.4 сая төгрөг, Эрдэнэс таван толгой ХК-ийн 150,000.0 сая төгрөг, Замын-Үүдийн Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2,497.4 сая төгрөг, нийт 267,578.8 сая төгрөг байна.

Аудитын илрүүлэлт:

- Уул уурхай хүнд үйлдвэрийн яам нь нэмэлт төсвөөс 242.2 сая төгрөгөөр ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхдээ Сангийн сайдын 2019 оны 74 тоот тушаалыг зөрчсөн, шатахуун, замын хуудасыг дутуу бөглөн, хэрэглэсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулаагүй, шатахуун авсан анхан шатны баримт дутуу бүрдүүлсэн, зориулалт бус зардлын ангилалаас зарцуулсан;
- Эрдэнэс Монгол ХХК нь томилолтоор явсан зам хоног болон байрны зардлыг 28.0 сая төгрөгөөр, нэмэгдэл цалин хөлсийг 4.4 сая төгрөгөөр тус тус илүү олгосон, ажилтны докторын сургалтын төлбөр, гишүүнчлэлийн хураамж 4.3 сая төгрөгийг байгууллагаас төлсөн, өөрийн хүсэлтээр ажлаас халагдсан ажилтнуудад 60.0 сая төгрөгийн тэтгэмж олгосон, зарцуулалтын норм хэтрүүлэн 10.7 сая төгрөгийн шатахуун илүү зарцуулсан;
- Ашигт малтмал, газрын тосны газар нь Төрийн үйлчилгээний албан хаагчдад 24.2 сая төгрөгийн мэргэшлийн зэргийн нэмэгдлийг журамд тусгаадаагүй магистр, мэргэшсэн жолоочийн үнэмлэхийг үндэслэн олгосон;
- Эрдэнэс ассет Менежмент ҮЦК ХХК нь Ажилтны хөдөлмөрийн гэрээ дуусвар болох үед илүү олгосон үндсэн цалин болон ээлжийн амралтын олговрыг тооцоо хийж суутгаагүй;

2.8.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 315,086.2 сая төгрөг болж, 217,846.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	10.4	17.3	6.8
Төлбөртэй үйлчилгээний авлага		26.7	26.7
Татаас, санхүүжилтийн авлага	95.8	122.0	26.1
Дансны авлага /ТӨҮГ/	62,364.4	247,387.3	185,022.8
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	270.4	3,768.5	3,498.1
Бусад авлага	34,499.0	63,764.3	29,265.3
Дүн	97,240.2	315,086.2	217,846.0
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	9,068.5	9,097.8	29.3
Төсөл/ сан			
Төрийн сан			
ТӨҮГ	88,171.7	305,988.4	217,816.6
Дүн	97,240.2	315,086.2	217,846.0

Эх сурвалж: Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдлийн 97.1 хувь буюу 305,988.4 сая төгрөг нь тайлант онд шилжиж ирсэн ТӨҮГ-уудын зээлээрх борлуулалтын авлага байгаа ба дараах байгууллагуудын авлага материаллаг дүнтэй байна. Тухайлбал:

- Эрдэнэс таван толгой ХК-ийн авлага 223,936.4 сая төгрөг
- Таван толгой төмөр зам ХХК-ийн авлага 26,589.2 сая төгрөг
- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын авлага 22,334.9 сая төгрөг
- Эрдэнэс Монгол ХХК-ийн авлага 12,405.2 сая төгрөг
- Ашиг малтмал, газрын тосны газрын авлага 9,084.0 сая төгрөг байна.

Мөн тайлант онд нийт 255,185.5 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, үүнээс 5 дээш жилийн насжилттай авлага 17,702.7 сая төгрөг байгаа нь олон жилийн насжилттай хугацаа хэтэрсэн, найдваргүй авлага нэмэгдэх эрсдэлтэй байна.

Харьяа ТӨҮГ-ууд нь тайлант онд ажиллагсадтай холбоотой болон нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг өмнөх оны мөн үеэс 3,505.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн, өмнөх оны авлагыг барагдуулаагүй байна.

Аудитын илрүүлэлт:

- Багануур ХК-ийн хувь хүмүүсээс авах авлага 677.7 сая төгрөгийн үлдэгдлийн 84.1 хувь буюу 596.6 сая төгрөгийг сэлбэг нийлүүлдэг 3 харилцагчаас авах авлага эзэлж байгаа бөгөөд өмнөх тооцоонуудыг дуусгаагүй, дараагийн мөнгийг олгодог, цаг хугацаандаа тооцоо нийлдэггүй, өмнөх гүйцэтгэх захирлын 2016 онд үүссэн кредит картын авлага 2.8 сая төгрөгийг зардлаар тусгасан;
- Шивээ-овоо ТӨХК нь 118.3 сая төгрөгийн авлагыг харилцагч байгууллагатай тооцоо нийлж баталгаажуулаагүй;
- Геологийн төв лаборатори ТӨҮГ нь өмнөх оны 341 харилцагчдын 397.3 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

2.8.3. Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 87,421.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 445,444.37 сая төгрөг болж, 358,023.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 3 Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төрийн өмчит үйлдвэр, аж ахуйн	8,743.0	12,366.2	3,623.2
Урьдчилж гарсан зардал	78,138.2	381,448.0	303,309.7
Урьдчилгаа тооцоо	539.8	51,630.1	51,090.3
Дүн	87,421.08	445,444.37	358,023.2
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	72,775.5	58,678.3	-14,097.2
Төсөл/ сан			
Төрийн сан			
ТӨҮГ	14,645.5	386,766.0	372,120.4
Дүн	87,421.0	445,444.3	358,023.2

Эх сурвалж: Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэлд тайлант онд нэмэгдсэн 358,023.2 сая төгрөгийн дараах ажил үйлчилгээний төлбөрүүд байна. Тухайлбал:

- Геологийн судалгааны зардлыг хуримтлуулан бүртгэснээс үүссэн урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл 58,172.2 сая төгрөг;
- Тайлант онд Таван толгой ХХК-ийн төмөр замын бүтээн байгуулалттай холбоотой урьдчилж төлсөн төлбөр 260,478.9 сая төгрөг;
- Эрдэнэс тавантолгой майнинг ХХК-ийн IPO болон гадаад, дотоодын 4 байгууллагаас 5 төрлийн зөвлөх үйлчилгээний гэрээний урьдчилгаа төлбөр нийт 5,521.5 сая төгрөг;
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Канад улсад зохион байгуулагддаг чуулга уулзалтын зардлын 52.1 сая төгрөг;
- Багануур ХК-ийн Вагнер Ази ХХК-аас хүнд даацын автомашин худалдан авах гэрээ, ус шүүрүүлэх байгууламжийг нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой Тавилан ХХК-тай хийсэн гэрээ, уулын дэд станц нүүлгэх ажлын Хасу Энерги ХХК-тай хийсэн гэрээний нийт 8,603.3 сая төгрөгийн урьдчилгааны үлдэгдэл тус тус байна.

Аудитын илрүүлэлт:

- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны геологийн судалгааны 2014-2019 онуудад хийж гүйцэтгэсэн зарим гэрээт ажлын биелэлтийг тухай бүр дүгнэж, судалгааны ажлын тайлан болон холбогдох материалыг хүлээн аваагүйгээс нийт 16,795.0 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийн тооцоог хийгээгүй он дамжуулан үлдээгдлээр бүртгэсэн байна.

2.8.4. Бараа материал

Бараа материалын оны эхний үлдэгдэл 120,939.4 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 480,917.9 сая төгрөг болж, 359,978.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 4 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал		252,043.7	252,043.7
Дуусаагүй үйлдвэрлэл		4,443.5	4,443.5
Бэлэн бүтээгдэхүүн	102,085.0	124,171.0	22,086.0
Хангамжийн материал	18,854.3	100,259.6	81,405.3
Дүн			
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	610.9	709.4	98.5
Төсөл/ сан			
Төрийн сан			
ТӨҮГ	120,328.4	480,208.5	359,880.0
Дүн	120,939.3	480,917.9	359,978.5

Эх сурвалж: Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаарх бараа материал нийт 2,279,143.7 сая төгрөгөөр нэмэгдэж, 1,919,165.1 сая төгрөгөөр хасагдсан байна.

Шивээ-овоо ТӨХК-ийн ашиглагдах боломжгүй 7,271.0 сая төгрөгийн, Багануур ХК-ийн 2,200.0 сая төгрөгийн бараа материал бүртгэлтэй байгаа ба Багануур ХК-ийн бараа материалын дансны үлдэгдлээс үндсэн хөрөнгийн шинж чанартай 6,606.1 сая төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэснээс шалтгаалжээ. Мөн тайлант онд сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланд шинээр нэгтгэгдсэн ТӨҮГ-уудын бараа материал нэмэгдсэнтэй холбоотой үлдэгдэл өсчээ. Тухайлбал:

Таван толгой төмөр зам ХХК-ийн 105,541.2 сая төгрөг, Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн 288,994.1 сая төгрөгийн бараа материал тус дансанд бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

Шивээ-овоо ТӨХК нь шууд гэрээ байгуулан бараа бүтээгдэхүүн худалдан авсан, өмнөх онд үлдэгдэлтэй бараа материалыг тайлант онд дахин худалдан авсан боловч ашиглаагүй, худалдан авсан 817.1 сая төгрөгийн сэлбэгийг ашиглаагүй байгаа зэрэг хэрэгцээ шаардлагагүй бараа материал, сэлбэг нөөцөлсөн байна.

2.8.5. Нөөцийн бараа

Нөөцийн барааны эцсийн үлдэгдэл 23,175.3 сая төгрөг байна.

Хүснэгт № 5 Нөөцийн барааны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Шатахууны нөөц	23,175.3	23,175.3	0.0
Дүн	23,175.3	23,175.3	0.0
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	23,175.3	23,175.3	0.0
ТӨҮГ			0.0
Дүн	23,175.3	23,175.3	0.0

Эх сурвалж: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Ашигт малтмал, газрын тосны газрын санхүүгийн тайлангийн нөөцийн бараа дансанд онцгой нөхцөлд зарцуулах 23,175.3 сая төгрөгийн шатахууны үлдэгдэлд тайлант онд өөрчлөлт гараагүй байна.

2.8.6. Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 12,074,016.8 сая төгрөг байсан, эцсийн үлдэгдэл 15,933,826.9 сая төгрөг болж, 3,859.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 6 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	457,559.4	3,565,104.7	3,107,545.3
Барилга, байгууламж, орон сууц	219,890.1	956,233.6	736,343.5
Авто-тээврийн хэрэгсэл	58,375.9	376,422.9	318,047.0
Машин тоног төхөөрөмж	99,207.5	1,673,475.0	1,574,267.5
Тавилга, аж ахуйн эд хогшил	4,888.6	50,339.5	45,450.9
Зам, гүүрний байгууламж	-	172,894.1	172,894.1
Батлан, хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	487.8	-	(487.8)
Бусад үндсэн хөрөнгө	5,890.2	110,521.1	104,630.9
Дуусаагүй, барилга байгууламж	68,817.5	225,216.8	156,399.3

Номын фонд	1.7	1.7	-
Биет бус хөрөнгө	11,216,005.5	11,272,189.4	56,183.9
Программ хангамж	4,972.0	21,120.3	16,148.3
бусад биет бус хөрөнгө	11,211,033.5	11,251,069.1	40,035.6
Бусад хөрөнгө ТӨҮГ	400,452.9	1,096,532.9	696,080.0
Дүн	12,074,017.8	15,933,826.9	3,859,809.2
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	25,694.1	64,557.5	38,863.4
ТӨҮГ	12,048,324.7	15,869,269.4	3,820,944.7
Дүн	12,074,018.8	15,933,826.9	3,859,808.1

Эх сурвалж: Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайланд онд Уул, уурхай хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланд Эрдэнэт үйлдвэр ХХК, Монросцветмет ТӨҮГ, Эрдэнэс Тавантолгой төмөр зам ХХК, Эрдэнэс таван толгой майнинг ХХК, Эрдэнэс силвер ресурс ХХК, Багануур ХК-уудын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс шалтгаалан 2,268,556.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 16,118.1 сая төгрөгөөр өссөн нь Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн авто замын эрхийг Итгэлт бээс ХХК-аар дахин үнэлгээ хийлгүүлэн 158,202.0 сая төгрөгөөр үнэлүүлэн үнэлгээний тайлан болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 10 дугаар тогтоолыг үндэслэн 1,432.2 сая төгрөгийг дахин үнэлгээний нэмэгдлээр тайлагнасан байна. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн авто замын засварын ажлыг 14,625.7 сая төгрөгөөр капиталжуулсан зэрэг нь үндсэн хөрөнгө өсөхөд нөлөөлсөн байна.

Харьяа төсөвт байгууллага, ТӨҮГ-ууд нь ТӨБЗГ-ын тогтоол, шийдвэрийн дагуу 228,588.4 сая төгрөгийн хөрөнгийг балансаас баланст шилжүүлсэн, 58,077.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хассан байна.

Дуусаагүй барилга дансанд 225,216.8 сая төгрөгийн дараах 5 харьяа ТӨҮГ-уудын хөрөнгө байна.Үүнд:

- Уул уурхайн хүнд үйлдвэрийн яамны хөрөнгө оруулалтын зардлын санхүүгийн тайлан 5,033.9 сая төгрөг;
- Эрдэнэс таван толгой ХК 15,640.8 сая төгрөг;
- Монголын газрын тос боловсруулах үйлдвэр ХХК 117,464.6 сая төгрөг;
- Эрдэнэс алт ресурс ХХК 1,238.4 сая төгрөг;
- Монголросцветмет ТӨҮГ 1,445.6 сая төгрөг;
- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ 84,393.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2.8.7. Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалтын эхний үлдэгдэл 1,725.640.1 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 2,628,650.8 сая төгрөг болж, 903,010.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 7 Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урт хугацаат хадгаламж		7,350.1	7,350.1
Урт хугацаат зээл	1,725,640.1	2,621,300.6	895,660.5
Дүн			
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
ТӨҮГ	1,725,640.1	2,628,650.8	903,010.6
Дүн	1,725,640.1	2,628,650.8	903,010.6

Эх сурвалж: Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урт хугацаат хөрөнгө оруулалтын дүн 903,010.6 сая төгрөгөөр өссөн дараах шалтгаантай байна. Тухайлбал:

- Эрдэнэс Оюу Толгой ХХК-ийн урт хугацаат хөрөнгө оруулалт 583,827.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Оюу Толгой ХК-ийн гаргасан хувьцааны Эрдэнэс Оюу Толгой ХХК-ийн 34 хувьд ногдох өөрчлөлтөөс үүссэн;
- Эрдэнэс Тавантолгой ХК-ийн урт хугацаат хөрөнгө оруулалт 311,725.5 сая төгрөгөөр өссөн нь Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөртэй холбоотой олгосон санхүүжилтүүдийн дүнгээр нэмэгдсэн байна.

2.8.8. Өр төлбөр

Нийт өр төлбөрийн оны эхний үлдэгдэл 787,780.4 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 1,465,872.1 сая төгрөг болж, 678,091.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 8 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Богино хугацаат зээлийн өглөг	86,892.7	103,443.6	16,550.9
Өглөг	239,864.1	576,523.9	336,659.8
Урьдчилж орсон орлого	117,807.3	105,339.3	(12,468.0)
Урт хугацаат зээл	343,216.3	680,565.3	337,349.0
Дүн	787,780.4	1,465,872.1	678,091.7
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	2,496.7	3,272.3	775.6
ТӨҮГ	785,283.7	1,462,599.8	677,316.1
Дүн	787,780.4	1,465,872.1	678,091.7

Эх сурвалж: Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат зээлийн 103,443.6 сая төгрөгийн өглөгөөс Эрдэнэс Монгол ХХК, Шивээ-овоо ХК, Эрдэнэс ассет менежмент ҮЦК, Эрдэнэс алт ресурс ХХК, Монголросцветмет ХХК, Багануур ХК, Эрдэнэс силвер ресурс ХХК-ийн арилжааны банкнаас авсан зээл 74,843.3 сая төгрөг, санхүүгийн бусад байгууллагаас авсан зээл 2,334.3 сая төгрөг байна.

Урт хугацаат зээлийн үлдэгдэлд харьяа ТӨҮГ-уудын дараах үлдэгдэл байна. Үүнд:

- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ 161,149.3 сая төгрөг
- Эрдэнэс таван толгой ХК 43,375.9 сая төгрөг
- Эрдэнэс таван толгой майнинг ХХК 154.8 сая төгрөг
- Эрдэнэс Монгол ХХК 225,896.7 сая төгрөг
- Эрдэнэс метан ХХК 851.0 сая төгрөг
- Шивээ овоо ХК 76,231.3 сая төгрөг
- Монголын газрын тос боловсруулах үйлдвэр ТӨҮГ 119,816.1 сая төгрөг
- МонАтом ХХК 5,877.1 сая төгрөг
- Монголросцветмет ТӨҮГ 1,582.7 сая төгрөг
- Багануур ХК 38,949.3 сая төгрөг тус тус байна.

Аудитын илрүүлэлт:

Багануур ХК-ийн өөрийн хөрөнгийн оролцоо 2018 онд 7.1 хувь байсан ба 2019 онд 6.6 хувьд хүрч төлбөрийн чадвар буурч тайлант онд нийт өр төлбөрийн дүн нь өөрийн хөрөнгөөс 14 дахин, богино хугацаат өр төлбөр авлагын дүнгээс дунджаар 10 дахин их байгаа нь эргэлтийн хөрөнгийн зохистой харьцаа алдагдаж, төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлж байна.

2.8.9. Засгийн газрын хувь оролцоо

Хүснэгт № 9 Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	16,878.6	10,491.9	-6,386.7
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	21,569.2	28,817.7	7,248.5
Өмч /хувийн/ /ТӨҮГ/	137.1	3.0	-134.1
Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/	11,197,207.7	11,197,208.7	1.0
Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/		1,356.7	1,356.7
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	1,732,221.7	2,624,922.0	892,700.3
Хуримтлагдсан үр дүн	889,483.9	3,678,815.7	2,789,331.8
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	9,183.5	219,507.2	210,323.7
Хяналтын бус хувь оролцоо		658.5	658.5
Дүн	13,866,681.7	17,761,781.4	3,895,099.7
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	120,417.4	144,374.0	23,956.5
ТӨҮГ	13,746,264.5	17,617,407.6	3,871,143.1
Дүн	13,866,682.0	17,761,781.7	3,895,099.7

Эх сурвалж: Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Геологийн судалгааны ажлын болон хөрөнгө оруулалтын зардал нийт 6,386.7 сая төгрөгийг өмнөх аудитын зөвлөмжийн дагуу өмчийн өөрчлөлтийн тайлангийн Засгийн газрын оруулсан капитал дансанд хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэсэн нь тайлант үеийн үр дүнд нөлөөлсөн байна.

Засгийн газрын оруулсан капитал дансанд Уул уурхай хүнд үйлдвэрийн яамны 304.1 сая төгрөг, Ашигт малтмал, газрын тосны газрын 10,187.8 сая төгрөгийн үлдэгдэл байна

Өмч /хувьцаат, ТӨҮГ/ дансанд Эрдэнэс таван толгой ХК-ийн 11,196,000.0 сая төгрөг, Шивээ овоо ХК-ийн 1,207.0 сая төгрөг, Таван толгой төмөр зам ХХК-ийн 1.0 сая төгрөгийн нийт 11,197,207.7 сая төгрөгийн хөрөнгө байршиж байна.

Өмч /төрийн, ТӨҮГ/ дансанд сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланд шинээр нэгтгэгдсэн болон байгуулагдсан ТӨҮГ-уудын өмч нэмэгдсэн байна. Тухайлбал: Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ 2,658.3 сая, Эрдэнэс таван толгой майнинг ХХК 2,852.8 сая, Багануур ХК 1,573.1 сая, Монголросцветмет ТӨҮГ 1,226.8 сая, Эрдэнэс алт ресурс ХХК 100.0 сая, Эрдэнэс силвер ресурс ХХК-ийн 1.0 сая төгрөг байна.

Хуримтлагдсан үр дүнгийн 2,789,331.7 сая төгрөгийн өсөлт нь шинээр нэмэгдсэн байгууллагууд, мөн Эрдэнэс таван толгой ХХК-ийн 1,035,574.7 сая төгрөг, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 497,501.1 сая төгрөгийн үйл ажиллагааны ашиг, харьяа газруудын тайлант оны үр дүн байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн тухай хуульд төсвийн ерөнхийлөн захирагч тайлант онд 404,050.0 сая төгрөгийн орлого улсын төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 298,469.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 73.9 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 10. Төвлөрүүлэх орлого/ сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	42,900.0	36,910.6	-5,989.4	86.0

Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр	2,300.0	5,532.1	3,232.1	240.5
Газрын тосны экспортын орлого	335,600.0	232,267.1	-103,332.9	69.2
Бусад орлого	12,000.0	4,275.6	-7,724.4	35.6
Өөрийн орлого /Сонгон шалгаруулалтын орлого/	11,250.0	19,484.1	8,234.1	173.2
Нийт дүн	404,050.0	298,469.5	-105,580.5	73.9

Эх сурвалж: Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Ашигт малтмал, газрын тосны газар нь тайлант онд батлагдсан Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 105,580.5 сая төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн байна.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 17 хөтөлбөрт зориулан 38,917.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 12,295.3 сая төгрөгийг урсгал зардалд, 26,621.9 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар тус тус батлагджээ.

Нийт зардлын 36,289.0 сая төгрөгийг улсын төсвөөс, 2,628.2 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Гүйцэтгэлээр улсын төсвөөс 33,176.3 сая төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагаанаас 2,323.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна. Төсвийн нийт урсгал болон хөрөнгө оруулалтын зардлын гүйцэтгэл 35,500.2 сая төгрөг буюу 91.2 хувь, 3,417.8 сая төгрөгөөр дутуу зарцуулсан байна.

Батлагдсан төсвөөс эдийн засгийн ангиллаар материаллаг дүнтэй дутуу зарцуулсан дараах зардлууд байна. Үүнд:

- *Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын 2,000.0 сая төгрөг, Геологи судалгааны ажлын Ховд-1 төслийн 890.5 сая төгрөгийн худалдан авах ажиллагаа амжилтгүй болсноос гүйцэтгэл гараагүй;*
- *Ашигт малтмал, газрын тосны газрын сургалтын урамшууллын зардалд 2,628.2 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос зарцуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 2,323.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж 304.3 сая төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй байна.*

Нэмэлт төсөв: Нэмэлт санхүүжилтийн тайлангаар Тогтвортой бичил уурхай төслөөс гэрээгээр 472.3 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, бараа ажил үйлчилгээний зардалд 279.2 сая, хөрөнгийн зардалд 155.1 сая нийт 434.3 сая төгрөг зарцуулж, тогтвортой бичил уурхай төсөл хаагдаж үлдэгдэл 4.2 сая төгрөгийг зарцуулаагүй буцааж шилжүүлсэн, 33.8 сая төгрөгийг оны эцэст Сангийн яаманд төвлөрүүлж, авлагаар тусгасан байна.

2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд эрхлэх асуудлын хүрээний 23 байгууллага, нэгжийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 3 санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан, 20 байгууллага аудитад хамрагдаж аудитаар 16 санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 4 санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 5,183,847.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 791,158.7 сая төгрөгийн алдааг залруулж, 53.1 сая төгрөгийн зөрчилд 10 төлбөрийн акт тогтоож, 416,188.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах 29 албан шаардлага, 3,976,447.4 сая төгрөгийн алдаа, зөрчилд 76 зөвлөмж хүргүүлээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 1,306,339.4 сая төгрөгийн алдаа, илрүүлснээс 451,049.2 сая төгрөгийн алдааг залруулж, 17,016.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага, 838,274.1 сая төгрөгийн 9 зөвлөмж хүргүүлээ. Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар геологийн судалгааны байгууллага, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны хөрөнгө оруулалтын санхүүгийн тайланг түүвэрт хамруулав.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас 451,094.2 сая төгрөгөөр зөрүүтэй нэгтгүүлсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд дахь үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл тодруулга тайлангийн эцсийн үлдэгдлээс 138,632.8 сая төгрөгөөр дутуу илэрхийлэгдсэн;
- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан дахь цэвэр хөрөнгө/өмчийн дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайлангийн дүнгээс 311,725.5 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн;
- Санхүүгийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлангийн үйл ажиллагааны орлого 690.9 сая төгрөгийг төсвийн тохируулга, дотоод устгалтыг давхардуулан хийснээс зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн албан шаардлага

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Геологи судалгааны 2014-2017 онуудад дууссан зарим гэрээт ажлын 107.0 сая төгрөгийн барьцаа хөрөнгийн өглөгийг Ашигт малтмал, газрын тосны газрын гэрээний биелэлт дүгнэсэн баримт ирүүлээгүй шалтгаанаар барагдуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага хүргүүлсэн.

2. Зарим гүйцэтгэгч байгууллагад буцаан олгох барьцаа хөрөнгийг урьдчилж орсон орлого дансанд бүртгэж, тайлагнасан ба мөнгөн хөрөнгийн дансанд уг барьцаа хөрөнгө үлдэгдлээр бүртгэгдээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллагаагүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага хүргүүлсэн.

3. Геологийн судалгааны 2014-2019 онуудад хийж гүйцэтгэсэн зарим гэрээт ажлын биелэлтийг тухай бүр дүгнэж, судалгааны ажлын тайлан болон холбогдох материалыг тухай бүр хүлээн аваагүйгээс нийт 16,795.0 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийн тооцоог хийгээгүй он дамжуулан үлдэгдлээр бүртгэсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 37 дугаар зүйлийн 37.1.7-д "төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу холбогдох дансанд бүртгэх, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай

тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага хүргүүлсэн.

4. Геологи судалгааны ажлын гэрээний хугацааг хэтрүүлсэн байгууллагуудад 42.9 сая төгрөгийн алданги тооцоогүй байна. Энэ нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2015 оны 108 дугаар тушаалаар батлагдсан "Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох тухай" журмын 3 дугаар зүйлийн 3.19-д "Төслийн геологийн даалгаврын хугацааг хэтрүүлж хэрэгжүүлсэн тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд төсөлд зарцуулсан нийт зардлын дүнгийн 0.03 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг төсөл гүйцэтгэгч нарт ногдуулах ба энэ тухай төрийн захиргааны байгууллага нь геологийн судалгааны төв гүйцэтгэсэн тухай гэрээг дүгнэсэн актад тодорхой заалт оруулан төрийн захиргааны төв байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ." гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага хүргүүлсэн.

Төсвийн ерөнхийлөн захирагчид 838,274.1 сая төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 9 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа төсвийн 2 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж, Ашигт малтмал, газрын тосны газрын санхүүгийн тайланд "Зөрчилгүй", Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд "Хязгаарлалттай" санал дүгнэлт өгч,

Аудитаар нийт 6,556.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 624.1 сая төгрөгийн алдааг залруулж, 0.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 5,878.2 сая төгрөгийн зөрчилд 8 албан шаардлага, 53.8 сая төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 5 зөвлөмжийг хүргүүлэв.

ТӨҮГ -ын санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа 18 ТӨҮГ-ыг аудитад хамруулж, 15 ТӨҮГ-ын санхүүгийн тайланд "Зөрчилгүй", Геологийн төв лаборатори ТӨҮГ, Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын санхүүгийн тайланд "Хязгаарлалттай" санал дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 3,870,951.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 339,485.4 сая төгрөгийн алдааг залруулж, 52.6 сая төгрөгийн зөрчилд 9 төлбөрийн акт тогтоож, 393,294.3 сая төгрөгийн зөрчилд 17 албан шаардлага, 3,138,119.5 сая төгрөгийн алдаа, зөрчилд 62 зөвлөмж тус тус хүргүүлсэн.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланд салбарын төрийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлан нэгтгэгдэж байна. Гэвч төсвийн ерөнхийлөн захирагч нь төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэхэд чиглэл өгөх, гэрээ байгуулах, дүгнэх, санхүүгийн үүрэгтэй холбоотой асуудлаар хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй байгаа асуудлаар Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар Засгийн газар болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт зөвлөмж хүргүүлэх шаардлагатай байна.

Дараагийн аудитаар авч үзэх дараах асуудлууд байна. Үүнд:

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын авлага, өглөгийг барагдуулсан, тооцоо нийлсэн эсэх,

2. Геологийн судалгааны ажил дансны хөрөнгө оруулалтын зарцуулалт, түүнийг гүйцэтгэл, бүртэл, тайлагнал батлагдсан журамтай нийцэж байгаа эсэх;
3. Төрийн өмчит үйлдвэрийн газрууд чөлөөт мөнгөн үлдэгдлүүдийг банкны хадгаламжийн дансанд байршуулж байгаа нь холбогдох дүрэм журамд нийцэж байгаа эсэх;

2.12. Шилэн дансны мэдээлэл

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 16 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 1 мэдээллийг байршуулаагүй байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчид өгсөн 39.8 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоосныг барагдуулсан, зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.

Нийт 7 зөвлөмж өгснөөс 4 зөвлөмжийг хэрэгжүүлж, 3 зөвлөмж хэрэгжих шатанд буюу зөвлөмжийн хэрэгжилт 87.1 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Залруулагдаагүй 4,392,689.1 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 43,647.2 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан тул хязгаарлалттай санал дүгнэлтийг өгч байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, СТОУС, НББОУС түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн аудитаар нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Балансын данстай холбоотой асуудал

3.1.1. Илрүүлэлт: Геологийн санхүүжилтийн аргачлал, хяналтын зардлын дансанд 0.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 2.6 сая төгрөгийн бараа материалыг тус тус бүртгэж тайлагнасан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16-дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллагаагүй байна.

3.1.2. Эрсдэл: Холбогдох заавар, журмыг мөрдөж ажиллаагүй байх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх;

3.1.3. Өгсөн зөвлөмж: Геологийн санхүүжилтийн аргачлал, хяналтын зардлын дансанд бүртгэлтэй байгаа бараа материал, үндсэн хөрөнгийг уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны шууд захирагчийн данс руу шилжүүлж бүртгэх.

3.1.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.2. Балансын данстай холбоотой асуудал

3.2.1. Илрүүлэлт: Харьяа ТӨҮГ-ууд нь нийт авлагаас 249,253.7 сая төгрөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй үүнээс 5 дээш жилийн насжилттай 11,770.9 сая төгрөг авлагын үлдэгдэлтэй, нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг өмнөх оноос 3,498.1 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн, өмнөх оны авлагыг барагдуулаагүй.

3.2.2. Эрсдэл: Олон жилийн насжилттай хугацаа хэтэрсэн, найдваргүй авлага нэмэгдэх, холбогдох журам, зааврыг мөрдөж ажиллаагүй байх;

3.2.3. Өгсөн зөвлөмж: Авлагыг тооцоо нийлж баталгаажуулах, насжилт өндөртэй авлагыг барагдуулах, шинээр авлага үүсгэхгүй, холбогдох журам, зааврыг мөрдөж ажиллах.

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.3. Балансын данстай холбоотой асуудал

3.3.1. Илрүүлэлт: Харьяа ТӨҮГ-ууд нь нийт 438,311.3 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй үүнээс 5 дээш жилийн насжилттай өглөг 84,780.9 сая төгрөг, ажиллагсадтай холбоотой болон татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг өмнөх оноос 116,496.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

3.3.2 Эрсдэл: Өглөг барагдахгүй байх, олон жилийн насжилттай өглөг нэмэгдэх, тооцоо нийлж баталгаажуулаагүй байх;

3.3.3 Өгсөн зөвлөмж: Өглөгийн тооцоо нийлж баталгаажуулж байх, барагдуулах арга хэмжээ авч ажиллах.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.4. Зардлын данстай холбоотой асуудал

3.4.1. Илрүүлэлт: Аргачлал, хяналтын зардлын санхүүжилтээс Геологийн байгууллагын ойн арга хэмжээний зарим зардалд 97.2 сая төгрөгийн зориулалт бусаар зарцуулсан, Энэ нь Төсвийн тухай хуулийн 16-дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллагаагүй байна.

3.4.2. Эрсдэл: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүйгээс үргүй зардал гарах, санхүүгийн тайлан алдаатай, буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй

3.4.3. Өгсөн зөвлөмж: Төсвийг зориулалт бусаар зарцуулахгүй байх

3.4.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.5. Зардлын данстай холбоотой асуудал

3.5.1. Илрүүлэлт: Геологи судалгааны ажлын 2019 оны санхүүжилтээс суутгах аргачлал хяналтын зардлыг 27.3 сая төгрөгөөр дутуу суутгасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Журмын журмын 3 дугаар зүйлийн 3.14-д " Геологи судалгааны ажлын хэрэгжилтийн явцад аргачлал, хяналтын зардлыг төсөл тус бүрийн өөрийн хүчээр гүйцэтгэх ажлын нийт дүнгийн 2.0 хүртэл хувьтай тэнцэх хөрөнгийг төсөл гүйцэтгэгчээс Төрийн захиргааны төв байгууллагын аргачлал, хяналтыг зардлын дансанд төвлөрүүлэн зарцуулна" гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

3.5.2. Эрсдэл: Геологи судалгааны ажлын гүйцэтгэлд тавих аргачлал, хяналттай холбоотой зардлыг санхүүжүүлж чадахгүй байх.

3.5.3. Өгсөн зөвлөмж: "Төсөл гүйцэтгэгчийн гүйцэтгэх ажлын санхүүжилтээс суутгаж буй аргачлал, хяналтын зардлыг үнэн зөв тооцож суутгах, Дээрх журамд аргачлал хяналтын зардлыг гүйцэтгэх ажлын нийт дүнгээс тооцно гэсэн боловч суутгалыг гүйцэтгэсэн ажлын санхүүжилтээс суутгаж байгааг анхаарч, журмын холбогдох заалтыг тодорхой болгох

3.5.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.6. Орлогын данстай холбоотой асуудлууд

3.6.1. Илрүүлэлт: Тайлант онд батлагдсан Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 105,580.2 сая, үйл ажиллагааны орлогыг 304.3 сая төгрөгөөр тус тус дутуу төвлөрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах

болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.6.2 Эрсдэл: Төсөвт төвлөрүүлэх орлого тасрах, батлагдсан зардлыг санхүүжүүлж чадахгүй байх.

3.6.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулиар батлагдсан Улсын төсөвт төвлөрүүлэх болон байгууллагын үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх, Улсын төсвийн болон байгууллагын үйл ажиллагааны орлогыг бодитой тооцоо судалгаанд үндэслэн үнэн зөв төлөвлөж байх.

3.6.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.7. Тухайн байгууллага, салбарын хууль эрх зүйн орчин холбоотой асуудал.

3.7.1. Илрүүлэлт: Уул уурхайн сайдын 2015 оны 108-р тушаалаар батлагдсан "Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журмыг шинэчлэн батлах тухай" журмын 3.14-дахь заалт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн зарчимтай нийцэхгүй, тодорхой бус байна.

3.7.2. Эрсдэл: Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үндсэн чиглэлүүдийн нэг Геологи судалгааны ажлын гүйцэтгэлийн үр дүнг тооцон гүйцэтгэгч байгууллагуудын санхүүжилтээс авах аргачлал хяналтын зардлыг журамд зааснаар бус суутгах эрсдэлтэй байна.

3.7.3. Өгсөн зөвлөмж: Уул уурхайн сайдын 2015 оны дугаар 108-р тушаал " Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журмыг шинэчлэн батлах тухай" энэ журмын 3.14-дахь заалтыг байгууллагын нягтлан бодох бүртгэлийн зарчим, стандарттай нийцүүлэн шинэчлэх.

3.7.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.8. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаатай холбоотой асуудал

3.8.1. Илрүүлэлт: Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны нягтлан бодох, бүртгэлийн бодлогын баримт бичигт салбарын хэмжээний санхүү, бүртгэл, тайлагналын талаар нэгдсэн арга зүй бодлогыг тодорхой тусгасан нэмэлт өөрчлөлт хийгдээгүй байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэж заасантай нийцэхгүй байна.

3.8.2. Эрсдэл: Санхүүгийн нэгтгэсэн тайлан буруу илэрхийлэгдэх, яамны нягтлан бодох, бүртгэлийн бодлогын баримт бичигт салбарын үйл ажиллагааны онцлог, санхүү, бүртгэл, тайлагналын нэгдсэн арга зүйгээр хангах нарийвчилсан заалтуудыг тусгаагүй байх;

3.8.3. Өгсөн зөвлөмж: Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны нягтлан бодох, бүртгэлийн бодлогын баримт бичигт үйл ажиллагааны онцлог, Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцүүлсэн салбарын хэмжээний санхүү, бүртгэл, тайлагналын талаар нэгдсэн арга зүй бодлогыг тодорхой тусгасан нэмэлт өөрчлөлт хийх, мөрдөж ажиллах.

3.8.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.9. Харьяа байгууллагуудад илэрсэн зөрчилтэй холбоотой асуудал

3.9.1. Илрүүлэлт: Уул уурхай хүнд, үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дотоод хяналт хангалтгүй, Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад хууль, эрх зүйн актыг мөрдөж ажиллаагүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ" 14 дүгээр зүйлийн 14.2.5-д "Өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах", 14.2.10-т "Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

3.9.2. Эрсдэл: Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад илэрсэн зөрчлийг давтан гаргах, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

3.9.3. Өгсөн зөвлөмж:

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад илэрсэн алдаа, зөрчлүүдэд өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагыг биелүүлж ажиллах, дотоод хяналтыг сайжруулах.

3.9.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 9 дүгээр сарын 1-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	970,314,370.7	2,333,934,128.3
МӨНГӨН ХӨРӨНГӨ	625,989,547.6	1,064,359,716.5
АВЛАГА	97,240,259.0	315,086,288.0
УРЬДЧИЛГАА	87,421,077.0	445,444,365.4
БАРАА МАТЕРИАЛ	120,939,357.6	480,917,933.8
НӨӨЦИЙН БАРАА	23,175,390.4	23,175,390.4
БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	15,548,739.0	4,950,434.2
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	13,684,147,996.6	16,893,719,738.3
УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	1,725,640,137.4	2,628,650,830.7
Урт хугацаат хадгаламж	0.0	7,350,144.8
Урт хугацаат зээл	1,725,640,137.4	2,621,300,685.8
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	11,958,507,859.2	14,265,068,907.7
Биет хөрөнгө	363,300,164.7	1,948,017,210.0
Биет бус хөрөнгө	11,194,754,697.0	11,220,518,785.4
Бусад хөрөнгө /ТӨҮГ/	400,452,997.4	1,096,532,912.3
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	14,654,462,367.3	19,227,653,866.6
НИЙТ ӨР ТӨЛБӨР	787,780,366.8	1,465,872,118.1
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	444,564,165.2	785,306,828.4
Богино хугацаат зээлийн өглөг	86,892,720.8	103,443,612.4
Өглөг	239,864,086.5	576,523,872.8
Урьдчилж орсон орлого	117,807,358.0	105,339,343.2
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	343,216,201.6	680,565,289.7
Урт хугацаат зээл	343,216,201.6	680,565,289.7
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	13,866,682,000.5	17,761,781,748.5
Засгийн газрын хувь оролцоо	13,866,682,000.5	17,761,123,199.5
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	16,878,631.6	10,491,929.8
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	21,569,211.6	28,817,755.5
Өмч /хувийн/ /ТӨҮГ/	137,190.0	3,000.0
Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/	11,197,207,710.0	11,197,208,710.0
Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	0.0	1,356,775.3
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	1,732,221,764.0	2,624,922,064.0
Хуримтлагдсан үр дүн	889,483,991.3	3,678,815,716.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	9,183,502.0	219,507,248.4
Хяналтын бус хувь оролцоо	0.0	658,549.0
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	14,654,462,367.3	19,227,653,866.6

4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,696,311,729.0	3,749,460,234.2
ТАТВАРЫН ОРЛОГО	42,666,881.8	42,644,525.1
Бусад татвар, төлбөр, хураамж	42,666,881.8	42,644,525.1
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,635,082,958.4	3,673,181,258.8
Нийтлэг татварын бус орлого	1,632,386,379.2	3,671,594,049.0
Тусламжийн орлого	2,696,579.3	1,587,209.8
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	18,561,888.8	33,634,450.2
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	884,830,090.4	2,180,975,832.0
УРСГАЛ ЗАРДАЛ	883,181,062.0	2,180,975,832.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	603,298,815.3	1,879,524,922.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,566,346.6	4,208,923.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	436,108.5	484,769.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	246,828.3	255,209.0
Хангамж, бараа материалын зардал	350,159.4	355,243.1
Нормативт зардал	1,000.0	725.1
Эд хогшил, урсгал засварын зардал	107,097.7	225,683.0
Томилолт, зочны зардал	441,330.1	917,681.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	575,995,146.5	1,870,903,770.2
Бараа үйлчилгээний бусад зардал	22,154,798.0	2,172,918.4
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	279,882,246.7	301,450,910.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	811,481,638.6	1,568,484,402.2
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	29,404,615.5	26,216,649.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4,404,884.1	1,385,951.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	836,481,370.0	1,593,315,100.6

4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,326,890,214.4	5,801,365,110.0
ТАТВАРЫН ОРЛОГО	42,666,881.8	42,644,525.1
Бусад татвар, төлбөр, хураамж	42,666,881.8	42,644,525.1
Бусад нийтлэг төлбөр, хураамж	42,666,881.8	42,644,525.1
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,265,660,399.5	5,725,088,276.2
Нийтлэг татварын бус орлого	2,262,963,820.2	5,723,501,066.4
Тусламжийн орлого	2,696,579.3	1,587,209.8
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	18,562,933.1	33,632,308.7
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,517,084,015.6	4,222,843,850.5
УРСГАЛ ЗАРДАЛ	1,517,084,015.6	4,222,843,850.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,237,092,923.3	3,916,738,255.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	40,695,559.8	342,573,297.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,967,930.8	85,777,699.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	547,376.0	223,345,977.1

Хангамж, бараа материалын зардал	34,002,296.5	1,368,772,155.7
Нормативт зардал	1,386.0	1,386.0
Эд хогшил, урсгал засварын зардал	114,120.0	288,062.0
Томилолт, зочны зардал	468,789.6	953,026.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,149,841,978.1	1,894,703,622.6
Бараа үйлчилгээний бусад зардал	453,486.5	323,028.8
ХҮҮ	0.0	4,572,839.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	279,991,092.2	301,532,755.6
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	809,806,198.8	1,578,521,259.5
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	1,194,508.5	32,513,875.3
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	113,595,021.7	882,230,682.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	113,595,021.7	882,230,682.0
Дотоод эх үүсвэрээр	113,595,021.7	882,230,682.0
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-112,400,513.2	-849,716,806.7
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-174,372,568.4	-290,434,284.0
Бусад эх үүсвэр	73,409,866.9	475,322,796.2
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	247,782,435.3	765,757,080.1
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	523,033,117.2	438,370,168.8
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	102,956,430.4	625,989,547.6
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	625,989,547.6	1,064,359,716.5

4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,879,228,090.0	0.0	12,879,228,090.0
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-35,447,805.6	0.0	-35,447,805.6
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	12,843,780,284.4	0.0	12,843,780,284.4
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	7,688,046.2	0.0	7,688,046.2
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	1,371,612.6	0.0	1,371,612.6
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
Өмчид гарсан өөрчлөлт	177,427,296.6	0.0	177,427,296.6
Зарласан ногдол ашиг	-66,609.3	0.0	-66,609.3
Тайлант үеийн үр дүн	836,481,370.0	0.0	836,481,370.0
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	13,866,682,000.5	0.0	13,866,682,000.5
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,579,502,625.2	0.0	1,579,502,625.2
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	15,446,184,625.7	0.0	15,446,184,625.7
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	17,175,601.5	0.0	17,175,601.5
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-6,386,701.9	0.0	-6,386,701.9

Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
Өмчид гарсан өөрчлөлт	895,396,321.3	0.0	895,396,321.3
Зарласан ногдол ашиг	-183,903,198.7	0.0	-183,903,198.7
Тайлант үеийн үр дүн	1,593,315,100.6	0.0	1,593,315,100.6
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	17,761,781,748.5	0.0	17,761,781,748.5

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	38,917,249.7	35,500,205.0	3,417,044.7	91.2
УРСГАЛ ЗАРДАЛ	12,295,300.2	11,768,806.1	526,494.1	95.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,402,654.3	9,181,680.4	220,973.9	97.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,021,269.6	3,915,663.0	105,606.6	97.4
Үндсэн цалин	2,602,281.4	2,366,653.6	235,627.8	90.9
Нэмэгдэл	801,493.3	997,171.5	-195,678.2	124.4
Унаа хоолны хөнгөлөлт	358,166.8	381,936.5	-23,769.7	106.6
Урамшуулал	259,328.1	169,901.3	89,426.8	65.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	438,091.8	438,091.8	0.0	100.0
Тэтгэврийн даатгал	297,902.4	297,902.4	0.0	100.0
Тэтгэмжийн даатгал	35,047.3	35,047.3	0.0	100.0
ҮОМШӨ-ний даатгал	28,037.8	28,037.8	0.0	100.0
Ажилгүйдлийн даатгал	7,009.5	7,009.5	0.0	100.0
Эрүүл мэндийн даатгал	70,094.8	70,094.8	0.0	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	109,537.2	108,332.5	1,204.7	98.9
Гэрэл, цахилгаан	24,105.6	22,516.9	1,588.7	93.4
Түлш, халаалт	72,006.4	75,073.0	-3,066.6	104.3
Цэвэр, бохир ус	11,197.7	9,185.0	2,012.7	82.0
Байрны түрээс	2,227.5	1,557.6	669.9	69.9
Хангамж, бараа материалын зардал	293,566.7	289,128.3	4,438.4	98.5
Бичиг хэрэг	78,173.8	76,277.3	1,896.5	97.6
Тээвэр, шатахуун	88,637.3	88,637.3	0.0	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	68,745.0	66,494.8	2,250.2	96.7
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	855.4	380.0	475.4	44.4
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	57,155.2	57,339.0	-183.8	100.3
Нормативт зардал	1,386.0	1,386.0	0.0	100.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,386.0	1,386.0	0.0	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	224,069.1	213,756.1	10,313.0	95.4
Багаж, техник, хэрэгсэл	84,020.4	77,703.8	6,316.6	92.5
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,138.4	2,138.4	0.0	100.0
Урсгал засвар	137,910.3	133,914.0	3,996.3	97.1
Томиллолт, зочны зардал	626,088.1	620,737.8	5,350.3	99.1

Дотоод албан томилолт	626,088.1	620,737.8	5,350.3	99.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,212,656.5	3,118,595.6	94,060.9	97.1
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,075,959.7	2,988,163.0	87,796.7	97.1
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,772.0	800.0	1,972.0	28.9
Даатгалын үйлчилгээ	40,847.5	40,156.0	691.5	98.3
Тээврийн хэрэгслийн татвар	6,966.0	6,645.7	320.3	95.4
Тээврийн хэрэгслийн оношилгоо	1,850.0	1,040.2	809.8	56.2
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	75,311.3	74,011.2	1,300.1	98.3
Газрын төлбөр	4,000.0	2,829.5	1,170.5	70.7
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4,950.0	4,950.0	0.0	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	475,989.3	475,989.3	0.0	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	475,989.3	475,989.3	0.0	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,892,645.9	2,587,125.8	305,520.1	89.4
Бусад урсгал шилжүүлэг	2,892,645.9	2,587,125.8	305,520.1	89.4
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	92,101.3	91,154.2	947.1	99.0
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,628,250.0	2,323,902.8	304,347.2	88.4
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	123,794.6	123,658.8	135.8	99.9
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	48,500.0	48,410.0	90.0	99.8
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	26,621,949.5	23,731,398.9	2,890,550.6	89.1
Бусад хөрөнгө	24,621,949.5	23,731,398.9	890,550.6	96.4
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	38,917,249.7	35,500,205.0	3,417,044.7	91.2
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	36,288,999.7	33,176,302.2	3,112,697.5	91.4
Улсын төсвөөс санхүүжих	36,288,999.7	33,176,302.2	3,112,697.5	91.4
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,628,250.0	2,323,902.8	304,347.2	88.4
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,628,250.0	2,323,902.8	304,347.2	88.4
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	526.0	576.0	-50.0	109.5
АЖИЛЛАГСАДЫН ТОО	263.0	288.0	-25.0	109.5
Удирдах ажилтан	30.0	30.0	0.0	100.0
Гүйцэтгэх ажилтан	182.0	182.0	0.0	100.0
Үйлчлэх ажилтан	51.0	51.0	0.0	100.0
Гэрээт ажилтан	0.0	25.0	-25.0	-25.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	263.0	288.0	-25.0	109.5
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	213.0	210.0	3.0	98.6
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	45.0	48.0	-3.0	106.7
Гэрээт ажилтан	0.0	25.0	-25.0	-25.0
Улс төрийн албан хаагч (УТ)	2.0	2.0	0.0	100.0

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	ТЕЗ цэвэр дүн
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	472,336.5
УРСГАЛ ЗАРДАЛ	317,236.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	279,204.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	88,600.8
Үндсэн цалин	88,600.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,285.6
Тэтгэврийн даатгал	6,285.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,840.0
Байрны түрээс	19,840.0
Хангамж, бараа материалын зардал	15,834.6
Бичиг хэрэг	2,398.5
Тээвэр, шатахуун	7,141.5
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	500.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,794.6
Эд хогшил, урсгал засварын зардал	13,210.0
Багаж, техник, хэрэгсэл	10,710.0
Урсгал засвар	2,500.0
Томилолт, зочны зардал	66,630.0
Гадаад албан томилолт	16,390.1
Дотоод албан томилолт	50,044.0
Зочин төлөөлөгч хүлээн авах	195.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	54,467.1
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	54,467.1
Бараа үйлчилгээний бусад зардал	14,336.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,336.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,032.4
Олгосон санхүүжилт, шилжүүлэг	38,032.4
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	4,235.9
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	33,796.5
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	155,100.0
Дотоод эх үүсвэрээр	155,100.0
Тоног төхөөрөмж	5,100.0
Бусад хөрөнгө	150,000.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	472,336.5
Нэмэлт санхүүжилтийн орлого	472,336.5
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	472,336.5

Хавсралт 1

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Д/д	№	Харьяа байгууллага	Аудитад хамрагдсан хэлбэр						Нийт зөрчил		Залруулсан алдаа		Акт		Албан шаардлага		Зөвлөмж		Үүнээс:				
			Итгэл үзүүлсэн	Түүвэрт	Дүгнэлт				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		Хариуцлага тооцуулах санал
					Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан													Тоо	Дүн	
		1	2	3	4	5	6	7	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21		
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ																							
I. УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН																							
1		Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд				1			15	1,306,339.4	2	451,049.2			4	17,016.1	9	838,274.1					
		ДҮН							15	1,306,339.4	2	451,049.2	-	-	4	17,016.1	9	838,274.1					
ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ БОЛОН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ АЖ АХУЙН НЭГЖ																							
1	1	Эрдэнэс-Тавантолгой ХК			1				5	21,112.3	1	16,052.3			2	-	2	5,060.0					
2	2	Эрдэнэс Ассет Менежмент ХХК			1				2	0.8			1	0.8			1	-					
3	3	Тавантолгой төмөр зам ХХК			1				4	26,065.0	1	26,059.0					3	6.0					
4	4	Монголросцветмет			1				4	83.0							4	83.0					
5	5	Мон Атом ХХК			1				6	4.2			1	0.2			5	4.0					

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

6	6	Багануур ХК			1			8	3,500.1			1	2.8	1	569.6	6	2,927.7			
7	7	Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ХХК			1			5	1,432.7	1	13.8			2	1402.1	2	16.8			
8	8	Шивээ-овоо ТӨҮГ			1			5	118.3					3	-	2	118.3			
9	9	Эрдэнэс Метан ХХК			1			2	888.6	1	886.9					1	1.7			
10	10	Эрдэнэс Монгол ХХК			1			8	1,546.9	1	1,439.5	4	47.4	1	60.0	2	-			
11	11	Эрдэнэс Оюу Толгой ХХК			1			5	22.0	1	11.0	1	1.1	1	9.9	2				
12	12	Эрдэнэс таван толгой майнинг ХХК			1			2	94.4							2	94.4			
13	13	Геологийн судалгааны төв ТӨҮГ			1			3	14.3					1	4	2	10.3			
14	14	Геологийн төв лаборатори ТӨҮГ				1		2	397.3							2	397.3			
15	15	Эрдэнэс алт ресурс ХХК			1			3	-							3				
16	16	Эрдэнэс силвер ресурс ХХК			1			10	778.2	5	736.4			1	-	4	41.8			
17	17	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ				1		45	3,812,225.0	27	294,088.9			3	391,187.7	15	3,126,845.0			
18	18	Шингэн түлш шилжүүлэн ачих байгуулламж ТӨҮГ				1		8	2,772.1	1	197.6	1	0.3	2	61.0	4	2,513.2			
		ДҮН	-	-	15	3-	-	127	3,870,951.8	39	339,485.4	9	52.6	17	393,294.3.	62	3,138,119.5			
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ																				
19	19	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам				1		6	342.9	1				1	318.1	4	24.8			
20	20	Ашигт малтмал, газрын тосны газар			1			10	6,213.7	1	624.1	1	0.5	7	5,560.1	1	29.0			
21	21	УУЯ-ны Хөрөнгө оруулалт			1			-												
22	22	Тогтвортой бичил уурхай төсөл																		
23	23	Геологийн байгууллага			1			-												

		ДҮН		1	1	1		16	6,556.6	2	624.1	1	1	8	5,878	5	53.8			
НИЙТ ДҮН				2	16	4		158	5,183,847.8	43	791,158.7	10	53.1	29	416,188.6	74	3,976,447.4			

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар тогтоосон төлбөрийн актын нэгтгэл

Д/д	Харьяа байгууллага	Төлбөрийн актын товч утга	Мөнгөн дүн /сая.төг/	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтан	
				Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
1	Эрдэнэс Оюу толгой ХХК	Томилолтын зардлыг 1.1 сая төгрөгөөр илүү олгосон	1.1	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Ц.Түмэнцогт, Г.Мөнхтөр
2	Эрдэнэс Монгол ХХК	Томилолтоор явсан, ирсэн зам хоногийн хоёр өдрөөр тооцсон, зам хоног болон байрны зардлыг баталсан хэмжээнээс 28.0 сая төгрөгөөр илүү олгосон.	28.0	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	П.Ганхүү, Д.Отгонцэцэг
		Ажилтаны докторантын сургалтын төлбөр, гишүүнчлэл хураамж 4.3 сая төгрөг байгууллагаас төлсөн нь Эрдэнэс Монгол ХХК-ийн дүрэм, журамд нийцэхгүй байна.	4.3		
		Нэмэгдэл цалин хөлсийг ажилласан хоногт ногдох цалингаас олгоогүй үндсэн цалингаас тооцон 4.4 сая төгрөг илүү олгосон.	4.4		
		Автомашин шатахууны зарцуулалтын норм хэтрүүлэн 10.7 сая төгрөг илүү зарцуулсан.	10.7		
3	Эрдэнэс ассет менежмент	Ажилтны хөдөлмөрийн гэрээ дуусвар болох үед илүү олгосон үндсэн цалин болон ээлжийн амралтын олговрыг тооцоо хийж суутгаагүй.	0.8	Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ерөнхий нягтлан бодогч	Б.Ууганхүү, Г.Ганцэцэг

4	Мон атом	Түрээсийн төлбөр гэж хувь хүний дансанд шилжүүлсэн 2,2 сая төгрөгнөөс хувь хүний орлогын албан татварын суутган тооцоогүй.	0.2	Захирал, нягтлан бодогч	Д.Далайжаргал, Д.Батзаяа
5	Багануур ХК	Өмнө нь ажиллаж байсан захиралын гүйцэтгэх захиралын 2016 оны картын кредит авлага 2.8 сая төгрөгийг анхан шатны баримтгүйгээр картын хуулгыг үндэслэн тайлант хугацааны зардлаар бүртгэсэн	2.8	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Э.Номинчулуун, П.Эрдэнээ
6	Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж	Тайлант хугацаанд 6 иргэнээс нийт 3.2 сая төгрөгийн худалдан авалт хийхгдээ 0.3 сая төгрөгийн ХХОАТ-ыг суутгаж шилжүүлээгүй байна.	0.3	Захирал, Ерөнхий нягтлан бодогч	Г.Гансүх, Б.Дэлгэрдалай
			52.6		
7	Ашигт малтмал, газрын тосны газар	Монгол улсын засгийн газрын 184 дүгээр тогтоолын 2. "албан ажлын хэрэгцээний автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан суудлын автомашиныг хотын дотор ажлын хоногт дунджаар 50 км-ээс хэтрүүлэхгүй хэрэглэж байхаар тогтоосугай" заалтыг зөрчин илүү шатахуун зарцуулсан	0.5	Дарга, нягтлан бодогч	Х.Хэрлэн, Т.Цэрэндулам
			0.5		
			53.1		

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар хүргүүлсэн албан шаардлагын нэгтгэл

Д/д	Харьяа байгууллага	Албан шаардлагын товч утга	Мөнгөн дүн /сая.төг/	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтан	
				Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
1	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	Барьцаа хөрөнгийн өглөгийг барагдуулаагүй байна.	107.0	Уул уурхай хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ерөнхий нягтлан бодогч	Г.Нандинжаргал М.Нямсүрэн
		Зарим гүйцэтгэгч байгууллагад буцаан олгох барьцаа хөрөнгийг урьдчилж орсон орлого дансанд бүртгэж, тайлагнасан ба мөнгөн хөрөнгийн дансанд уг барьцаа хөрөнгө үлдэгдлээр бүртгэгдээгүй байна	70.2		
		Геологийн судалгааны 2014-2019 онуудад хийж гүйцэтгэсэн зарим гэрээт ажлын биелэлтийг тухай бүр хүлээн аваагүйгээс нийт 16,795.0 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийн тооцоог хийгээгүй он дамжуулан үлдэгдлээр бүртгэсэн	16,796.0		
		Геологи судалгааны ажлын гэрээний хугацааг хэтрүүлсэн байгууллагуудад 42.9 сая төгрөгийн алданги тооцоогүй байна.	42.9		
			17,016.1		
2	Эрдэнэс Оюу толгой ХХК	Эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр 9.9 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан	9.9	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Ц.Түмэнцогт, Г.Мөнхтөр
3	Эрдэнэс Монгол ХХК	Эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр хөрөнгө худалдав авсан нь ТӨБЗГ-ын журамтай нийцэхгүй байна.	-	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	П.Ганхүү, Д.Отгонцэцэг
		Өөрийн хүсэлтээр ажлаас халагдсан ажилтнуудад тэтгэмж олгосон.	60.0		
5	Эрдэнэс таван толгой ХК	Эргэн төлөлт хийгдээгүй байгаа авлагатай холбоотой асуудлаар		Хууль зүйн газар хариуцсан дэд захирал	Ц.Амартүвшин
		Хувьцааны бүртгэлийн талаар		Стратеги, хөгжлийн газар хариуцсан дэд захирал	Т.Цогтбаяр
6	Монгол газрын тос боловсруулах ТӨҮГ	Агарт ХХК, Блюдингс технологи ХХК, Хангай бигэр ХХК, Нутгийн зам ХХК-уудтай өглөг, авлагын тооцоо нийлж ажиллаагүй	1,372.3	Гүйцэтгэх захирал, Санхүү, эдийн засгийн албаны дарга	Д.Алтанцэцэг, Б.Чинтуяа
		Шинэ жилийн арга хэмжээ, улсын баяр наадам тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагаанд 29.8 сая төгрөг зарцуулсан	29.8		
7	Багануур ХК	Хувь хүмүүсээс авах авлагын тооцоо нийлдэггүй.	569.6	Ерөнхий нягтлан бодогч, мөнгөн хөрөнгийн нягтлан бодогч	П.Эрдэнээ, Б.Балжинням

8	Геологийн судалгааны төв	1993-2003 онд үүссэн авлагыг тооцоо нийлээгүй, барагдуулаагүй байна.	4.0	Захирал, Ерөнхий нягтлан бодогч	Н.Ганболд, Т.Батбилэг
9	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь “Жуулчин уорлд турс” ХХК-аас 2020 оны Токиогийн Олимп үзэх аялал худалдан авах багц гэрээ байгуулж, аялалд оролцох ажилтнуудын нэрс тодорхойгүй, Ерөнхий захирлын тушаал гараагүй байхад 2 удаагийн гүйлгээгээр 653.2 сая төгрөгийн шилжүүлсэн.	635.2	Захирал, Ерөнхий нягтлан бодогч	Х.Бадамсүрэн Ц.Мөнхболд
		Шууд гэрээ байгуулсан 426,760.2 сая төгрөгийн 320 гэрээт ажлаас тендер зарласан боловч ТБОНӨХӨАҮХТХ-ийн 34 дүгээр зүйлийн 34.1.2-ийн дагуу 6,305.6 сая ажил үйлчилгээний 25 гэрээ, 34.1.1-ийн дагуу 29,375.9 сая төгрөгийн ажил үйлчилгээний 4 гэрээ, 34.1.8 заасны дагуу 817.0 сая төгрөгийн худалдан авалтын 6 гэрээ байгуулж, 390,291.7 сая төгрөгийн нийлүүлэх бараа, гүйцэтгэх ажлын 285 гэрээ шууд байгуулсан.	390,291.7		
		“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын 2019 оныг угтах Тэргүүний ажилтнуудын шинэ жилийн сүлд модны наадмын үеэр “Алтан азтан”-аар шалгарсан Б.Хишигчулуун, Ж.Ундрах нарт Ерөнхий захирлын 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/20 дугаар, 2018 оны 12 сарын 18-ны өдрийн А/1093 дугаар тушаалуудаар 53.6 м2 139.24 сая төгрөгийн үлдэх өртөгтэй орон сууц, 46.8 м2 121.58 сая төгрөгийн үлдэх өртөгтэй орон сууцуудыг шилжүүлсэн.	260.8		
10	Шингэн түлш шилжүүлэн ачих байгууллагамж ТӨҮГ	Мон-суль ХХК-ийн 5.5 сая төгрөгийн авлагыг Лекс Ойл ХХК-ийн орлогоор хааж бүртгэсэн байна.	5.5	Ерөнхий нягтлан бодогч	Б.Дэлгэрдалай
		Петролиум продакшн ХХК-тай шилжүүлэн ачилтын гэрээ байгуулаггүй, шилжүүлэн ачилтын 55.5 сая төгрөгийн авлагыг Ай си ай си ХХК-ийн орлогоор хааж бүртгэсэн байна.	55.5	Ерөнхий нягтлан бодогч	Б.Дэлгэрдалай
11	Шивээ овоо ТӨХК	Нягтлан бодох бүргэлийн бодлогод стандартын өөрчлөлтийг тусгаагүй	-	Захирал, нягтлан бодогч	Ц.Энхтүвшин, Н.Энхжаргал
		Орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй	-		
		Мэргэжлийн актуарчин оролцуулж байх	-		
			393,294.3		
12	Ашигт малтмал, газрын тосны газар	Газрын тосны тухай хуулиар зөвшөөрөгдсөн, бүтээгдэхүүн хуваах гэрээний үндсэн дээр бүрдүүлдэг "Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжих орлого"-ыг төсөвт тусгаж батлуулалгүйгээр зарцуулсан. Өмнөх/Өмнөх аудитаар зөвлөмж өгсөн хэрэгжээгүй/	1,117.8	Дарга, Ахлах нягтлан бодогч	Х.Хэрлэн Т.Цэрэндулам
		Төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг тасалсан	303.8		
		2019 онд бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу 27 компаниас сургалтын урамшуулалд 4,161.5 сая төгрөг төвлөрүүлэхээс 2,260.3 сая төгрөг төвлөрүүлж 1,901.2 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна	1,901.2		

		2019 онд бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу 27 компаниас төлөөлөгчийг дэмжих санд 3,601.5 сая төгрөгийг төвлөрүүлэхээс 1,117.8 сая төгрөгийг төвлөрүүлж, 1,943.7 сая төгрөгийг дутуу төвлөрүүлсэн.	1,943.7		
		Төрийн үйлчилгээний албан хаагчидад мэргэшлийн зэргийн нэмэгдлийг магистр, мэргэшсэн жолоочийн үнэмлэхийг үндэслэн олгосон.	24.2		
		Бүртгэлээс гадуур "Эрлийн гэрээ"-гээр 10 автомашин ашиглаж байгаагаас 263.2 сая төгрөгийн 3 автомашины гэрчилгээг АМГТГ-ын нэр дээр шилжүүлсэн боловч санхүүгийн тайланд бүртгээгүй.	263.2		
		Эрлийн гэрээний бусад 7 автомашин нь хувь хүний болон өөр компаниудын нэр дээр байдаг. Тайлант онд эдгээр автомашинтай холбоотой 6.2 сая төгрөгийн зардлыг АМГТГ-аас гаргасан.\	6.2		
13	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	Бараа үйлчилгээний бусад зардлаас үндсэн хөрөнгө худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах зарцуулалтанд хяналт тавих" 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"	318.1		
			5,878.2		
			416,188.6		



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 04 дугаар сарын 24

№ 01/232

Улаанбаатар хот

САГ- 2020/25/СТА - ТЭЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасан цаглабарт хугацаанд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Геологи судалгааны 2014-2017 онуудад дууссан зарим гэрээт ажлын 107.0 сая төгрөгийн барьцаа хөрөнгийн өглөгийг Ашигт малтмал, газрын тосны газрын гэрээний биелэлт дүгнэсэн баримт ирүүлээгүй шалтгаанаар гүйцэтгэгч байгууллагад чөлөөлөх ёстой өглөгийг барагдуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Барьцаа хөрөнгийн дансанд бүртгэлтэй байгаа хаагдаагүй төслүүдийн геологийн даалгаврын биелэлтийг дүгнэн, судалгааны ажлын тайлангуудыг хүлээн авч барьцааг хаах талаар тодорхой арга хэмжээг авч ажиллах.
2. Дээрх зөрчлийг арилгах, холбогдох арга хэмжээ авч ажиллаж биелэлтийг 2020 оны 07 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Уул уурхайн хүнд үйлдвэрийн яамны төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал, Ерөнхий нягтлан бодогч М.Нямсүрэн нарт даалгав.

ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР
Ц.НАРАНЧИМЭГ
П.АМАРСАНАА

АЛБАН ШААРДЛАГЫГ

ЗӨВШӨӨРСӨН:

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА
Г.НАНДИНЖАРГАЛ
ЕРӨНХИЙ НИЯГТЛАН БОДОГЧ
М.НЯМСҮРЭН

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 04 дугаар сарын 24

№ 01/233

Улаанбаатар хот

С.СТ-2020/25/СТА-ТЭЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасан цаглабарт хугацаанд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Геологийн судалгааны 2014-2019 онуудад хийж гүйцэтгэсэн зарим гэрээт ажлын биелэлтийг тухай бүр дүгнэж, судалгааны ажлын тайлан болон холбогдох материалыг тухай бүр хүлээн аваагүйгээс нийт 16,795.0 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийн тооцоог хийгээгүй он дамжуулан үлдэгдлээр бүртгэсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 37 дугаар зүйлийн 37.1.7-д "төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу холбогдох дансанд бүртгэх, тайлагнах" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ..." Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д заасныг тус тус үндэслэн шаардах нь:

1. Хэрэгжсэн боловч он дамжин урьдчилгаа төлбөр дансанд бүртгэлтэй байгаа хаагдаагүй төслүүдийн геологийн даалгаврын биелэлтийг дүгнэн, судалгааны ажлын тайлангуудыг хүлээн авч урьдчилгаа төлбөрийг хаах талаар тодорхой арга хэмжээг авч ажиллах.
2. Дээрх зөрчлийг арилгах, холбогдох арга хэмжээ авч ажиллаж биелэлтийг 2020 оны 07 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Уул уурхайн хүнд үйлдвэрийн яамны төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал, Ерөнхий нягтлан бодогч М.Нямсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
ПАМАРСАНАА

АУДИТОР

ЗӨВШӨӨРСӨН:

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

Г.НАНДИНЖАРГАЛ
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ
М.НЯМСҮРЭН

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлэхгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2020 оны 04 дугаар сарын 24

№ 01/234

Улаанбаатар хот

СМ- 2020/25/СТА-ТЭВ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасан цаглабарт хугацаанд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Геологи судалгааны ажлын гэрээний хугацаа хэтрүүлэн тайлангаа хамгаалсан байгууллагуудын хэтрүүлсэн хоног тутамд "Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох тухай" журам болон зөвлөх үйлчилгээний гэрээнд заасны дагуу алдангийг шийвэрлэх тухай үүрэг өгсөн боловч хугацаа хэтрүүлж тайлангаа хамгаалсан байгууллагуудаас 42.9 сая төгрөгийн алданги тооцоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах", Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2015 оны 108 дугаар тушаалаар батлагдсан "Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох тухай" журмын 3 дугаар зүйлийн 3.19-д "Төслийн геологийн даалгаврын хугацааг хэтрүүлж хэрэгжүүлсэн тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд төсөлд зарцуулсан нийт зардлын дүнгийн 0.03 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг төсөл гүйцэтгэгч нарт ногдуулах ба энэ тухай төрийн захиргааны байгууллага нь геологийн судалгааны төв гүйцэтгэсэн тухай гэрээг дүгнэсэн актад тодорхой заалт оруулан төрийн захиргааны төв байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ."

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ..." Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

Дээрх зөрчлийг арилгах, холбогдох арга хэмжээ авч ажиллаж биелэлтийг 2020 оны 07 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Уул уурхайн хүнд үйлдвэрийн яамны төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал, Ерөнхий нягтлан бодогч М.Нямсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
П.АМАРСАНАА

ЗӨВШӨӨРСӨН:

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

Г.НАНДИНЖАРГАЛ
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ
М.НЯМСҮРЭН

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлэхгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 04 дугаар сарын 24

№ 01/235

Улаанбаатар хот

САГ-2020/25/СТА-ТЭЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасан цаглабарт хугацаанд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний зарим гүйцэтгэгч байгууллагад буцаан олгох барьцаа хөрөнгийг урьдчилж орсон орлого дансанд бүртгэж, тайлагнасан ба мөнгөн хөрөнгийн дансанд уг барьцаа хөрөнгө үлдэгдлээр бүртгэгдээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллагаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Урьдчилж орсон орлогоор бүртгэсэн 70.7 сая төгрөгийн барьцаа хөрөнгийг залруулах бичилт хийж үнэн зөв бүртгэх.
2. Дээрх зөрчлийг арилгах, холбогдох арга хэмжээ авч ажиллаж биелэлтийг 2020 оны 07 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Уул уурхайн хүнд үйлдвэрийн яамны төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал, Ерөнхий нягтлан бодогч М.Нямсүрэн нарт даалгав.

ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТОР
П.АМАРСАНАА

АЛБАН ШААРДЛАГЫГ

ЗӨВШӨӨРСӨН:
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА
Г.НАНДИНЖАРГАЛ
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ
М.НЯМСҮРЭН

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу харууцагч албан тушаалтанд харууцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing, consisting of 25 rows.

